

**Л.Цэндийн намтар, улс төрийн
үйл ажиллагааны тухайд**

Доктор /PhD/ Д.Сүхбаатар

Лувсанцэрэнгийн Цэнд 1920 онд Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Охиндий хэмээх нутагт төржээ. Энэ тухай Монгол улсын хүн ам, хөрөнгө малын тооллогын 1929 онд нэгтгэсэн дүнгийн Зүүнбүрэн уулын хошууны Баян-Эрхэт сумын данс бүртгэлд Тогтохын Лувсанцэрэн нас 44, хүү Цэгмид нас 17, хүү Цэнд нас 9, эхнэр Жаргал нас 41 хэмээн тэмдэглэжээ. Тэрээр 1931 онд Зүүнбүрэнгийн бага сургуульд орсноор эцэг Чүлтээмийн номын нэр Лувсанцэрэн гэдэг нэрээр овоглох болжээ. 1932-1933 онд Алтанбулагийн бага сургуульд, дараа нь Улаан-Үд хотын Монгол Рафакт суралцан 1938 онд Москва хотын төмөр замын сургуульд шилжин суралцаж, 1939 оны V сард сургуулиа амжилттай төгсөж, галт тэрэгний жолооч, слесарь, төмрийн дархан, токарьчин, фрезерчний мэргэжил давхар эзэмшжээ.

Удалгүй тэрбээр нарийн төмөр зам Монголын талд шилжихэд Депогийн даргаар томилогдон ажиллаж байгаад 1942 онд цэргийн албанад татагдаж, IX морин хороонд алба хааж байхдаа 1942 оны VII сарын 22-нд МАХН-д гишүүнээр элсчээ.

Л.Цэнд 1943 онд Ардын цэргийн жанжин штабын даргын туслахаар томилогдон ажиллаж байгаад 1944 оноос БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн референтээр ажиллах болов. 1945 онд Л.Цэнд Москва хотын эдийн засгийн дээд сургуульд суралцахын зэрэгцээ Москвагийн радиогийн монгол хэлний редакцид ажиллаж байгаад сургуулиа төгсөөд, "БНМАУ-ын аж үйлдвэрийн хөгжил ба улс орныг үйлдвэржүүлэх асуудал" сэдвээр эдийн засгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалж, 1953 оны VIII сараас БНМАУ-ын Улсын төлөвлөгөөний комиссын даргаар томилогдон ажиллах болсон. Тэрбээр 1954-1964 онуудад БНМАУ-ын АИХ-ын депутататаар сонгогдон 1960 оноос АИХ-ын даргын албыг хашиж, 1954-1957 онуудад БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга бөгөөд Улсын төлөвлөгөөний комиссын дарга, 1957-1959 онуудад БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн I орлогч дарга бөгөөд Улсын төлөвлөгөөний комиссын дарга, 1957 оны III сарын 30-нд хуралдсан МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлаар МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны орлогч гишүүн, 1957 оны VII сарын 6-нд хуралдсан Намын Төв Хорооны VI бүгд хурлаас МАХН-ын Төв Хорооны УТТ-ы гишүүнээр сонгогдон, 1963 оны XII сард хуралдсан МАХН-ын Төв хороонд V бүгд хурлаар Л.Цэндийг "Эрх тушаал хөөцөлдсөн", "Намч биш үйл ажиллагаа явуулсан" хэмээн нам, төрийн дээд байгууллагуудын сонгуульт ажлаас нь чөлөөлж, 1964 оноос Тосонцэнгэлийн Мод боловсруулах комбинатын даргаар томилжээ. Тэрээр 66 насандaa хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн байна.

1952 онд БНМАУ-ын Ерөнхий сайд Х.Чойбалсан насан өөд болж, Улсын Их Хурлын 1952 оны V сарын 27-ны зарлигаар Ю.Цэдэнбалыг БНМАУ-ын Ерөнхий сайдар томилон ажиллуулах болжээ. Энэ үеэс эхлэн ЗХУ болон социалист орнууд дайны дараах үеийг өөрөөр харахыг оролдож, нэг хүнийг тахин шүтэх асуудлыг хөндөж эхэлсэн билээ.

МАХН-ын TX-оос Д.Дамбыг "Нэг хүнийг тахин шүтэх үзлийн хор уршигтай тэмцэх асуудалд зарчимч бишээр хандаж 1937-1940 оны дутагдал, завхрал бүхнийг Х.Чойбалсанд ганцааранд нь тохохыг оролдож, өөрийгөө хамтын удирдлагын зарчмыг нэвтрүүлсэн хүн болгон мандуулахыг зорьж махран хөөцөлдсөнөөс биш нэг хүнийг тахин шүтсэний хор уршигийг бүр мөсөн арилгах талаар тууштай арга хэмжээ боловсруулан явуулаагүй" хэмээн буруутгаж, 1959 оны III сарын 27-31-нд хуралдсан НТХ-ны III бүгд хурлаар "Үндсээрхэг үзлийг хөхүүлэн дэмжсэн, улс орны түүхэн ололтыг үл тоомсорлосон, нам улсын удирдах боловсон хүчнийг гүтгэн дайрч, хутган үймүүлэх арга хэрэглэж, намын нэгдлийг задлан эвдэх" гэсэн хэмээн яллаж, НТХ-ны УТТ-ы гишүүн, НТХ-ны нарийн бичгийн даргын ажлаас чөлөөлжээ.

Дээрхи хэлмэгдүүлэлтүүд нь Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн нэгдэл нягтралыг бий болгох өөрийг нь шүүмжилдэг, нэг хүнийг тахин шүтэх асуудлыг ул суурьтай авч үзэх, нам, улсын ажлын дутагдлыг чөлөөтэй шүүмжлэхийн эсрэг хийгдсэн алхам байлаа. Дараагийнх нь Л.Цэндийн асуудал байсан юм.

МАХН-ын ТХ-ны ээлжит V бүгд хурал 1963 оны XII сарын 20-нд нээгдэн, 2 хоног үргэлжлэхдээ "ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын коммунист ажилчны намуудын нэгдүгээр нарийн бичгийн дарга, Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлгөөний дүнгийн тухай", "Хятадын коммунист намын удирдагчдаас дэлхийн коммунист хөдөлгөөнд гаргаж байгаа зөрөлдөөн ба МАХН-ын бодлогын тухай", "Барилга байгуулалтын ажлын одоогийн байдал, түүнийг цаашид сайжруулах арга хэмжээний тухай", "Барилгын байгуулалтын ажлыг намаас удирдаж байгаа байдлын тухай "Завхан, Өвөрхангай аймгийн намын хороодын хавсралт илтгэл хэлэлцэхээр төлөвлөж байжээ. Гэвч Л.Цэндийн "Намч биш ажил явууллагын тухай" асуудлыг авч хэлэлэх байдлаар зохион байгуулжээ. Уг хурлаар Л.Цэндийг "нам улсын чухал чухал салбарыг удирдуулахаар намаас хүлээлгэсэн үүргээ үнэнч шудрага биелүүлээгүй, эрх тушаал ахих зорилгодоо цаг, хүч чадлаа зориулж, өөрийгөө элдэв аргаар магтуулан мандуулахыг эрмэлздэг, үндсэрхэг үзлийг дэмждэг, боловсон хүчнийг хооронд нь мөргөлдүүлдэг зэрэг ял тулгаж, түүний намч биш ажил явууллага нь намын эгнээний нэгдэл нягтралд хор хохирол учруулж байна" гэж дүгнээд, МАХН-ын Улс Төрийн Товчооны бүрэлдэхүүн болон МАХН-ын Төв Хорооны гишүүнээс хасаж, МАХН-ын төв хорооны II нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлжээ.

Л.Цэндийн амьдралын туршлага, олж авсан мэдлэг боловсрол Монгол орны хөгжилд зайлшгүй хэрэгтэй байлаа. Түүнийг хариуцлагатай ажил албанаас халагдах болсныг Ю.Цэдэнбал судлаач зарим түүхчид зөвхөн Ю.Цэдэнбалыг зөвтгөх үүднээс тайлбарлаж байгаа нь нэгд зохиогчийн үзэл санаа хэт давамгайлсан, хоёрт, түүхэн үнэнийг гүйвуулахад хүрч хандах сэтгэлгээ бага байгаагийн илрэл юм. Л.Цэндийг буруутгаж байгаа цөөн баримтуудаас тодруулбал:

Mash нууц.

"Хайрт жолоодогч багш маршал Чойбалсан,

HTX-ны нарийн бичгийн дарга нөхөр Цэдэнбал нар Танаа!

Та бүхний амрыг эрж, бүтээлт их ажилд чинь амжилтыг хүсэхийн ялдамд бидний хэдэн нөхөд манай улсын одоогийн хөгжлийн зарим чухал асуудлуудыг лавлан асууж та бүхнээс тодорхой хариулт авахыг хүсэж байна.

Үүнд: **Нэгдүгээр асуудал.** БНМАУ Монгол Ардын Хувьсгалт Намын удирдлагын дор, их Зөвлөлт Социалист Улсын сэтгэл харамгуй их тусламжийг хүлээн ирсний ачаар намын X их хурлын үест капиталист бус хөгжлийн зам дээр эргэлтгүй гарч, одоо тэр замаар улмаар хөгжсөөр байна. Үүнээс үндэслэн одоо манай улс социализмыг байгуулах явдалд шууд шилжин орох цаг болсон гэж үзэж болох уу?

Хоёрдугаар асуудал. Манай улс Зөвлөлт Холбоот улсын бүрэлдэхүүнд багталцан оролгүйгээр капиталист бус замаар амжилттай хөгжиж ирсэнтэйгээ адил социалист нийгмийг бүрэн төгс байгуулж чадах эсэх? Социализм манай оронд бүрмесөн ялах явдал Зөвлөлтийн Холбоонд багталцан орох явдалтай уялдсан байх уу? үгүй юу? Хэрвээ уялдсан байвал СССР-тэй манай улсын нэгдэх явдалд саад тогтор болж байгаа гадаад ба дотоодын ямар учир шалтгаан байгаа вэ?

Гуравдугаар асуудал. Нийгмийн хөгжлийн хуулийн үүднээс үзэхэд социализмыг байгуулах явдалд зайлшгүй аж үйлдвэрийг хөгжүүлэн үйлдвэрчний тоог олшруулж, ажилчин ангийн диктатурыг батжуулдаг байна. Зөвлөлтийн урьд хоцрогдмол байсан республикуудын социализмыг байгуулсан туршлага ба ардын ардчилсан орнуудын одоогийн практик нь энэ хөтөлбөргүй хуулийг батлан нотлож байна. Манай улсын одоогийн туршлагыг үзвэл бидний санаход, энэ талаар гойд онцлог байна. Манай орны энэ онцгой байдлыг юугаар тайлбарлах вэ?

Дөрөвдүгээр асуудал. Зөвлөлт улсын аж үйлдвэр нь тусгаар тогтносон манай улсад социализмыг байгуулах явдлын материаллаг суурь нь болох уу? Хэрвээ болох

аваас манай хоёр улсын хоорондын эдийн засаг, соёлын харилцаа ба гадаад худалдааны талаар ямар нэгэн гойдны шинэчлэлт гарах уу?

Тавдугаар асуудал. Манай улсын одоогийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуй нь цаашид социализмыг байгуулахад материаллаг суурь болж чадах уу? Хэрэв чадах аваас үүнд ямар үндсэн шинэчлэлт, хувиралтууд шаадагдах вэ? Нөхөр Сталины зөвлөснийг удирдлага болгон Х их хурлаас тус улсын малын тоог ойрын ирээдүйд 200 саяд хүргэх зорилт тавьсан билээ. Намын XI их хурлаас ойрын 2-3 таван жилийн дотор малын тоог 3-4 дахин нэмэгдүүлэх хэрэгтэй гэжээ. Хэрвээ энэ нь их хурлын үед малын тоог 20 орчим сая байсан гэж бодвол 60-80 сая тоонд хүрмээр бидэнд ойлгогдож байна. Гэтэл ТХ-ы I сарын бүгд хурал 12-13 жилийн дотор малын тоог 50 саяд хүргэх зорилгыг тавьжээ. Намын XI их хурал ба Төв Хорооны I сарын бүгд хурлын шийдвэрүүд нь Х их хурлаар тавьсан 200 саяд хүргэх тухай зорилгын үргэлжлэл буюу тодорхойлол гэж ойлгож болох уу? Хэрвээ тийм бол ямар арга замаар тэр зорилгод хүрч болох вэ? Мал аж ахуйд гарах үндсэн шинэчлэлт, хувиралт нь малын тоог дээр дурьдсан тоонд хүргэхийн тулд гарах уу? Эсхүл мөн тоонд хүрсэн хойно, түүгээр суурь болгон хийгдэх үү?

Зургадугаар асуудал. Ардын аж ахуйтанд малаа өсгөх төлөвлөгөө тогтоосон явдал нь намын их ба бүгд хурлаас заасан зорилтыг биелүүлэхэд шийдвэрлэх үндсэн арга зам болж чадах уу? Ер нь манай улсын хувийн өмчит аж ахуйнуудыг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх бололцоотой болгосон эдийн засгийн талын нөхцлүүд юу вэ?

Долдугаар асуудал. Тус улсын эдийн засгийн үндэс болсон мал аж ахуй нь ардын хувийн өмчинд байгаа цагт улсын гарг байгаа аж үйлдвэр, тээвэр, банк, гадаад худалдаа, сангийн аж ахуй, хадлангийн станцууд, бэлчээр газар ба түүний баялаг олох эдийн засагт командлах салбар болж байгаа хувийн өмчит нүүдлийн мал аж ахуйд түшиглэж захирагдаж байх уу?

Наймдугаар асуудал. Манай улсын дотор хувийн аж ахуйтнуудыг хамтралжуулах явдлын нөхцлүүд нь одоо гүйцэд бүрэлдсэн гэж үзэж болох уу? Хэрэв бүрэлдээгүй бол чухам ямар нөхцөл нь дутагдаж байна вэ?

Манай орны нөхцөл байдалд ардын өмчит аж ахуйтнуудыг социализмын байгуулалд өргөнөөр татан оролцуулахын шийдвэрлэх гол арга замууд ямар байх вэ? Зөвлөлт улсад нийтээр хамтралжуулсан туршлагаар хөдөө аж ахуйн артельд орох уу? Эсхүл одоогийн байгаа ардын энгийн нэгдэл нь хөдөө аж ахуйн артельд шилжихийг заавал дэмжих шат буюу хэлбэр болох уу?

Есдүгээр асуудал. Ардын аж ахуйн хувийн сонирхол санаачлагыг дээшлүүлэхэд чиглүүлэн нам, засгаас авч байгаа урамшуулах арга хэмжээнүүд /олон төрлийн хөнгөлөлт, тусламж, шагнал/ нь тэдгээрийг хамтралжуулах явдалд бэлтгэж байгаа арга хэмжээнүүд гэж үзэх үү? Эсхүл эдгээр арга хэмжээнүүд нь жижиг буржуйлаг шинжтэй ардын аж ахуйтны хувийн өмчөө хадгалах ба бэхжүүлэх эрмэлзлэл хандлагыг батжуулахад хүргэх тал байна уу? Үндсэн бодлогын эдгээр гол асуудлуудыг зөвөөр шийдвэрлэх явдал нь энэ талаар ямагт маргалдаантай байдаг намын идэвхтэй кадрууд ба өргөн олон сэхээтний сэнхрэн ухамсарлах ба хүмүүжих явдалд туйлын их ач холбогдолтой байна. Учир иймд эл асуудлыг Та бүхний өмнө тавьж, ойрын цагт хангалттай хариулт авахыг гүнээ итгэнэ.

С.Авирмэд, Б.Бадарч, Г.Галбадрах, Д.Төмөр-Очир, Ц.Дүгэrsүрэн, Л.Цэнд. 1950.VII.3. Улаанбаатар хот¹ хэмээх¹ энэхүү ил захильтыг олонд ил тод хэвлэгдсний дараа "БНМАУ-ыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах тухай" санал гэгч сүржин нэр зүүж "... Монгол улсаа яаж хөгжүүлэх вэ? гэсэн эх оронч санаа тод харагддагыг хэлэхийн ялдамд өөрийн ард түмний тусгаар тогтнолоо хамгаалж үлдэх хүч бололцоог дутуу үнэлсэн, үгүйсгэсэн хандлага нэвт шингэсэн байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Чухам иймэрхүү

¹ Х.Пүрэвдагва. С.Туяа. "Будант жилүүдийн эмгэнэл буюу Лувсанцэрэнгийн Цэнд". УБ., 1999 он. 89-р тал.

үүгүйсгэх үзлийнхээ улмаас эдгээр зохиогчдын зарим нь хожим намаасаа зэмлэл хүртэж байсныг энд санаад илүүдэхгүй бизээ.² гэж зохиогчдыг буруутган нам нь энэхүү суржин нэртэй захидалын улмаас шийтгэсэн мэт гүйвуулан бичжээ.

Тэгвэл 1953 онд Улс төрийн Товчооны хурал дээр Улс төрийн Товчооны гишүүн, улсын прокурор Б.Жамбалдорж "ЗХУ-ын нэг хамсаатан больё" гэсэн санал гаргахад Бумцэндээс бусад нь зөвшөөрч, тогтоол гаргах болж, төслийг Б.Жамбалдорж, ДЯЯ-ы сайд Цэдэв, ГЯЯ-ы сайд Н.Лхамсүрэн нар боловсруулах болжээ. Ю.Цэдэнбал ч "Улс төрийн товчооны гишүүд энэ асуудлыг НТХ-ны бүгд хурал, АИХ-ын чуулганд оруулахыг шаардсан юм" гээд Д.Дамбад "Тэр тогтоолыг гаргуулахгүй байх нь зүйтэй"³ гэсэн байдаг.

Монгол төрийн уламжлалт сэтгэлгээнд ямагт хүчирхэг улс гүрний төрийн ивээлд тусгаар тогтолцоо авч явах бодлого байснаас гадна ЗХУ-д нэгдэх асуудал харин ч нам төвтэй төрийг 40 шахам жил удирдсан Ю.Цэдэнбал болон түүнийг тойрон хүрээлгэгчийн дунд хүчтэй яригдаж байжээ.

Харин нэр бүхий зургаан хүний гарын үсэгтэй захидалд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал яагаад хариулт өгөөгүй.

Ю.Цэдэнбал судлаач Ц.Жамбалсүрэн уг хариултыг үзээгүй байж яагаад нэр бүхий зургаан хүнийг буруутгав. Эдгээр зургаан хүний нэг болох Л.Цэндийг шийтгэсэн МАХН-ын ТХ-ны V бүгд хурлын 1963 оны XII сарын 21-ний өдрийн хуралдаанд Л.Цэндийг шүүмжлэхээр нэрээ өгсөн 43 хүнээс 30 нь шүүмжилж, 13 нь бичгээр шүүмжээ өгөх болоход, дээрх шүүмжлэгчдээс Монгол улсыг ЗХУ-д нэгтгэх саналыг дэвшиүүлсэн гэх нэр бүхий зургаан хүн, түүний дотор буй Л.Цэндийг юуны учир энэ асуудлаар шүүмжилсэнгүй вэ? зэрэг асуултууд одоо ч хариугаа нэхсээр байна.

Л.Цэндийн тухай асуудлыг хэлэлцэхэд УТТ-ны гишүүн, нарийн бичгийн даргын ажлаас халж, НТХ-ны бүрэлдэхүүнээс гаргах саналд хуралд оролцогчдоос ганц Лувсансамбууг татгалзахад "Л.Цэндэд авах арга хэмжээ хөнгөн байна, намаас хөөх ёстой юм" гэсэн саналыг нь түүний өмнөөс Ю.Цэдэнбал мэдэгдэж байжээ.

Мөн судлаач Ц.Жамбалсүрэн "1932 оны хэлэлцээрээр Тувад /алдаж/ байсан тэр Давст уулыг 1958 онд Л.Цэнд толгойлсон хилийн хэлэлцээрийн комисс Тувагийн нутаг гэж тооцсон нь нэг ёсны сонин давтталт болжээ."⁴ хэмээн тэмдэглээд, Л.Цэндийг улс төрийн давхар бодлоготой оролцсон хэмээн буруутгажээ. Тэрээр Давст уулын хувь заяа анхлан шийдэгдэхэд Ю.Цэдэнбал 16 настай сурагч байсан тул түүнд буруугүй гэжээ.

Тэгвэл Л.Цэнд 1932 онд Алтанбулагийн бага сургуульд 12 настай суралцаж байжээ. Харин Л.Цэнд 1958 онд удаан үргэлжилсэн хилийн хэлэлцээрийг нэг мөр болгох комиссыг толгойлж байсан бол Ю.Цэдэнбал БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргаар ажиллаж байлаа.

1963 оны XII сарын 20-ны өдөр эхэлсэн МАХН-ын ТХ-ны V бүгд хурлыг ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх намын дээд сургуулийн сюутан, НТХ-ны бүгд хурлын гишүүн Б.Нямбуу "Хөдөлмөрчид НТХ-ны бүгд хурлаар юу хэлэлцэх бол, ямар чухал асуудал шийдвэрлэсэн бол гэдгийг сонсох биш, харин хэн хэнийгээ авч хаяваа гэдгийг сонсох төдий болжээ. НТХ-ы бүгд хурал яаж бэлтгэгдэж, ямар байдлын дунд явагдаж өнгөрдгийг Төмөр-Очир, Цэнд нарыг хэлэлцсэн 2 удаагийн бүгд хурлаар жишээ авч болно.

Төмөр-очир, Цэнд нарыг намын удирдлагаас зайлцуулсан явдал зөв зүйтэй байсан. Харин хурлыг зохион байгуулсан арга хэлбэр нь марксист-ленинист намын хэв хэмжээнд хэрхэвч байж болохгүй зүйл юм. Нөхөр Цэндийн асуудлыг хэлэлцсэн бүгд хурлын явцад Цэндийн асуудал дороос урсгалаар гарч ирээд шийдвэрлэгдсэн юм биш, энэ бол нөхөр Цэдэнбал өөрөө санаачлан удирдаж барагцаалбал сарын өмнөөс маш нарийн зохион байгуулалттай хуйвалдааны замаар бэлтгэгдсэн юм. Хурал болохоос нэг

² Ц.Жамбалсүрэн. "Ю.Цэдэнбал ард түмэндээ хүргэх үнэн өчил" УБ., 1996 он. 61-р тал.

³ Мөн тэнд 63-р тал.

⁴ Ц.Жамбалсүрэн. Ю.Цэдэнбал ард түмэндээ хүргэх үнэн өчил. УБ., 1996 он. 93-р тал.

сарын өмнө Лувсанчоймбол: Өнгөрсөн онд Цэндийн асуудлыг анх сөхөж тавьсны хувьд доорхи 2 зүйлээр туслалцаа үзүүлнэ үү? гэж нөхөр Цэдэнбал хүсэж байна.

1. Москвад эмчлүүлж байгаа Н.Жагваралтай уулзаж Цэндийн асуудлыг бүгд хуралд хэлэлцүүлэхийг шаардах, ятгах.
2. Цэндийн асуудлыг хэлэлцэхийг шаардсан захидалыг МАХН-ын НТХ-ны нарийн бичгийн дарга нөхөр Ц.Дүгэrsүрэнд өг гэсэн хоёр хүсэлтийг надад тавьсан" хэмээн тэмдэглэж зохион байгуулалтайгаар Цэндийг хэлмэгдүүлсэн бүгд хурлын тухай тайлбарлажээ.

Л.Цэнд 1961 оны XII сард Улаанбаатар хотын намын идэвхтний хурлыг бүх аймаг, орны удирдах хүмүүсийн оролцоотойгоор хуралдуулж, уг хурал дээр ЗХУКН-ын ХХII их хурлын шийдвэрийг Сталиныг тахин шүтэж байсан үеийн завхралын асуудлыг хэлэлцсэн хэмээн нэг хүнийг тахин шүтэж байсан үеийн хор уршигийг арилгах асуудлыг бүх намын хэмжээгээр хурц тавьж хэлэлцүүлнэ. Хэрэв амжилт олохгүй бол "Чи багш болно биз, би нэгдлийн төлөвлөгч болно биз" хэмээн МАХН-ын НТХ-ны суртал ухуулгын хэлтсийн эрхлэгч Цэдэнжавт хэлснээр намын нэгдлийг задлах, намч бус үйл ажиллагаагаа идэвхжүүлсэн гэдэг.

Харин Л.Цэндийг 1963 оны МАХН-ын V бүгд хурал дээр шүүмжилсэн хүмүүсийн хэлсэн үгнээс үзвэл:

Мэдээлэл, Радиогийн хэрэг эрхлэх газрын дарга Зундуй – Цэндийн намын эсрэг үйл явдалд Хятадын нөлөө байна уу? гэж бодмоор зүйл байх юмаа. Бас II бүгд хурал дээр Төмөр-очир Цэндийн тухай шүүмжлэхдээ "Л.Цэнд нь Хятадад очиж ирээд Мао Цзе Дүн ёстой ухаантай хүн юм, ёстой ардчилал тэнд байна. Хятадаас сурах хэрэгтэй" гэж байсан. Мөн нэгдэлчдийн их хурлаас гаргах уриалгад Жагварал нэгдэл социалист хөдөлмөрийн хөдөлгөөнийг өрнүүлэх тухай оруулах санал тавихад Төмөр-Очир элдэв үгээр Б.Жагваралыг дайрч манай хөдөө аж ахуй социалист болох хаа ч байсан юм. Жижиг хөрөнгөтнүүд тийм амар социализмжихгүй гэхэд түүнийг Цэнд дэмжин уг урианаас социалист хөдөлмөрийг хөдөө өрнүүлэх тухайг хассан юм. Гэтэл тэр хөдөлгөөн Төмөр-Очир, Цэнд нартай хамаарахгүйгээр хөдөө нэгдэл, сангийн аж ахуйд өрнөж манай урагшлах хөдөлгөөнд хүчин зүйл болоод байна. Манай ард түмэн жижиг хөрөнгөтний үзэлтэй биш харин Төмөр-Очир, Цэнд нар өөрсдөө жижиг хөрөнгөтний үзэлтэй болохоо харуулав.

МАХН-ын НТХ-ны орлогч гишүүн С.Ядамсүрэн – Л.Цэнд Улс Төрийн Товчооны гишүүн, ТХ-ны даргын өндөр нэрээр намын кадрт харгисладаг талаарх нилээд олон баримт гаргаж чадна аа. Нөхөр Цэнд УТТ-ны өндөр нэрээр далайлгаж, нам, улсын ажил хийж яваа боловсон хүчинүүдийн нэр төрийг олны өмнө муутган ажлыг нь явцгүй болгохыг их оролддог.

МАХН-ын УТТ-ны гишүүн Д.Майдар – Тэгэхээр Цэндийг дэмжиж байгаа хүн байгаа юм. Ямар хүмүүсүүд дэмжиж байна вэ? Үндсэргэг үнэр ханхалсан хүмүүс дэмжиж байна. Зөвлөлтэд дургүй, Зөвлөлтийг муулсан хүмүүс дэмжиж байна. Зарим чалчаа ажил хийхийн оронд дэмий хоосон ярьдаг хүмүүс дэмжиж байна. Зарим төөрөгдөж буй запуучууд дэмжиж байна.

Улсын төлөвлөгөөний комиссын дарга Т.Рагчаагийн шүүмжлэлд – Төмөр-Очир үндсэргэг үзэл санаагаар намын бодлогын эсрэг бол Цэнд нь намын нэгдлийн эсрэг, түүнчлэн Зөвлөлт Холбоот Улсын худалдааны зөв бодлогын эсрэг хардаж сэргэх талаараа үндсэндээ ижил юм. Тэрээр "... Манай улсын гадаадад худалдаж байгаа түүхий эд хямд үнэтэй байхад тэндээс авч байгаа машин техник, төхөөрөмж өндөр үнэтэй байна. Зөвлөлтэд явахдаа зарим техник төхөөрөмжийн өөрийн ертгийг мэдэх хэрэгтэй юм" гэж байсан нь биднийг Зөвлөлт улс мөлжин хохируулж байна гэдэг ойлголтод хэнийг ч хүргэх санаа юм гэх мэтчилэн шүүмжилж, бүгд хурлын гишүүд Л.Цэндэд санал нэгтэй арга хэмжээ авчээ.

Л.Цэндийн улс төрийн үйл ажиллагаанд холбогдох МАХН-ын ТХ-ны 1963 оны V бүгд хурлын протоколд тэмдэглэгдсэн шүүмжлэлүүд нь түүнийг зохион байгуулалттай хэлмэгдүүлснийг нотлох түүхэн баримт болж байна.

Summary

“To the issue of the L.Tsend's biography and political activities”

By D.Sukhbaatar.

There is a need to prove properly and sort out the biography and political activities of the L.Tsend.

From political historic point of view it's important to enrich by historical documents either it's positive or negative. Therein, the removal of L.Tsend at the V Party Conference was organized and prepared by Yu.Tsedenbal and his surroundings.